



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/06-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsogjargalb@audit.gov.mn</p>
---	--

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.10 № 19

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Д.ХҮРЭЛСҮХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд Стандартчилал хэмжилзүй хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 835,451.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 822,135.2 мянган төгрөгийг зарцуулсан.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 12 зорилт 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг СХЗГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/384 дүгээр тушаалаар 93.2 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	37,038,460.5	148,105,655.7
31	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	8,987,462.9	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,987,462.9	-
3121	Төгрөг	8,987,462.9	-
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	8,987,462.9	-
33	АВЛАГА	-	115,396,552.9
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	115,396,552.9
35	БАРАА МАТЕРИАЛ	28,050,997.6	32,709,102.8
351	Түүхий эд материал	7,874,281.6	8,240,937.0
35110	Тусгай зориулалттай материал	275,000.0	275,000.0
35130	Эм боох материал	7,599,281.6	7,965,937.0
354	Хангамжийн материал	20,176,716.0	24,468,165.8
35410	Бичиг хэргийн материал	4,025,810.0	4,776,260.0
35420	Аж ахуйн материал	12,797,346.0	16,676,995.8
35430	Сэлбэг хэрэгсэл	259,000.0	259,000.0
35440	Түлш, шатах тослох материал	400,000.0	400,000.0
35450	Барилгын засварын материал	550,000.0	550,000.0
35460	Хүнсний материал	-	1,840.0
35470	Бусад хангамжийн материал	2,144,560.0	1,804,070.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	280,797,675.1	378,398,876.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	280,797,675.1	378,398,876.2
392	Биет хөрөнгө	239,657,675.1	336,070,876.2
39201	Барилга, байгууламж, орон сууц	128,011,400.0	143,297,131.0
39202	Хуримтлагдсан элэгдэл /Барилга, байгууламж, орон сууц	(35,578,853.3)	(43,116,618.6)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,375,000.0	71,375,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл/Авто-тээврийн хэрэгсэл	(31,268,750.0)	(37,953,125.0)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	141,290,832.7	223,504,832.7
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,050,515.5)	(75,799,689.5)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,054,196.0	12,261,756.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,821,027.7)	(7,783,875.6)
39214	Бусад үндсэн хөрөнгө	115,443,667.8	87,354,999.1
39215	Хуримтлагдсан элэгдэл	(97,319,626.0)	(42,590,885.0)
39217	Ном	5,521,351.0	5,521,351.0
393	Биет бус хөрөнгө	41,140,000.0	42,328,000.0
39301	Програм хангамж	775,000.0	2,095,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(775,000.0)	(907,000.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,206,000.0	41,206,000.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	(66,000.0)	(66,000.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	317,836,135.7	526,504,531.8
4	ӨР ТӨЛБӨР	-	22,066,434.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	22,066,434.0
413	Өглөг	-	22,066,434.0

Архангай аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4136	Бусад өглөг	-	22,066,434.0
41361	Байгууллагад төлөх өглөг	-	16,426,434.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	5,640,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧ	317,836,135.7	504,438,097.8
51	Засгийн газрын хувь оролцоо	317,836,135.7	504,438,097.8
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	135,912,688.0	135,912,688.0
51101	- төрийн	135,912,688.0	135,912,688.0
512	Хуримтлагдсан үр дүн	61,517,151.3	248,119,113.5
51220	Тайлант үеийн үр дүн	-	186,601,962.2
51210	Өмнөх үеийн үр дүн	61,517,151.3	61,517,151.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	120,406,296.3	120,406,296.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	317,836,135.7	526,504,531.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	1,134,392,084.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	303,254,784.8
120	Нийтлэг татварын бус орлого	-	303,254,784.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	182,524,090.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,540,510.0	182,524,090.0
120009	Бусад орлого	8,987,462.9	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	119,231,885.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	924,450.0	1,498,809.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	831,137,300.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	761,269,400.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	664,217,400.0	761,269,400.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	69,867,900.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,100,000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,725,900.0	69,867,900.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,388,661.0	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	-	946,536,997.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	946,536,997.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	923,707,785.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	674,104,065.3
210101	Үндсэн цалин	299,055,838.8	327,106,328.2
210102	Нэмэгдэл	144,978,988.2	228,255,053.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,082,804.1	70,194,083.9
210104	Урамшуулал	26,938,530.9	48,548,600.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	87,685,134.1
210201	Тэтгэврийн даатгал	43,744,999.0	61,223,183.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,146,459.0	6,586,435.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,573,231.0	3,411,028.0

Архангай аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	2,573,231.0	3,291,717.8
210205	Эрүүл мэндийн даатгал	10,292,918.0	13,172,770.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	52,087,125.7
210301	Гэрэл, цахилгаан	2,795,397.0	3,937,928.0
210302	Түлш, халаалт	43,708,900.0	45,494,881.0
210303	Цэвэр, бохир ус	1,922,386.1	2,654,316.7
2104	Хангамж, бараа материалын зардал	-	10,509,676.0
210401	Бичиг хэрэг	3,898,937.0	4,305,181.0
210402	Тээвэр, шатахуун	1,021,500.0	2,440,200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,606,340.0	2,101,520.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,182,880.0	1,662,775.0
210408	Бараа материал акталсны зардал	2,691,823.3	-
2105	Нормативт зардал	-	10,688,497.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,201,134.0	8,539,217.6
210502	Хоол, хүнс	3,344,060.0	3,239,280.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	12,071,520.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,802,400.0	-
210604	Урсгал засвар	4,716,800.0	12,071,520.0
2107	Томилолт, зочны зардал	-	25,410,000.0
210702	Дотоод албан томилолт	23,345,200.0	25,410,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	10,429,252.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	935,700.0	9,800,740.0
210803	Даатгалын үйлчилгээ	161,292.0	179,912.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,000.0	41,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	576,000.0	-
210807	Газрын төлбөр	80,400.0	80,400.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	29,400.0	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	509,700.0	327,200.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	39,632,515.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,280,640.0	1,192,100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,752,040.0	204,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,746,391.2	38,236,415.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	22,829,211.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	13,695,031.8
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,630,035.0	8,095,031.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,937,000.0	5,600,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	9,134,180.1
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,210,119.3	9,134,180.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III = I - II)	-	187,855,087.2
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	1,253,125.0
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-бараа материал	695,730.0	1,253,125.0
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI = IV - V)	-	(1,253,125.0)
7	НИЙТ ҮР ДҮН (VII = III + VI)	-	186,601,962.2

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	846,959,933.9	1,013,661,390.0
I.I	ҮЙЛ АЖИЛЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	846,959,933.9	1,013,661,390.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,527,972.9	182,524,090.0
120	Нийтлэг татварын бус орлого	52,540,510.0	182,524,090.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	52,524,090.0	182,524,090.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,540,510.0	182,524,090.0
120009	Бусад орлого	8,987,462.9	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	785,431,961.0	831,137,300.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	664,217,400.0	761,269,400.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	664,217,400.0	761,269,400.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,214,561.0	69,867,900.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,100,000.0	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,725,900.0	69,867,900.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,388,661.0	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	794,060,671.0	1,006,043,121.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	794,060,671.0	1,006,043,121.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	718,886,516.7	867,817,357.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	511,056,162.0	674,104,065.3
210101	Үндсэн цалин	299,055,838.8	322,541,829.8
210102	Нэмэгдэл	144,978,988.2	232,819,551.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,082,804.1	70,194,083.9
210104	Урамшуулал	26,938,530.9	48,548,600.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,330,838.0	87,685,134.1
210201	Тэтгэврийн даатгал	43,744,999.0	61,223,183.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,146,459.0	6,586,435.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,573,231.0	3,411,028.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,573,231.0	3,291,717.8
210205	Эрүүл мэндийн даатгал	10,292,918.0	13,172,770.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,881,875.7	52,087,125.7
210301	Гэрэл, цахилгаан	2,795,397.0	3,937,928.0
210302	Түлш, халаалт	57,164,092.6	45,494,881.0
210303	Цэвэр, бохир ус	1,922,386.1	2,654,316.7
2104	Хангамж, бараа материалын зардал	8,697,939.0	8,035,900.0
210401	Бичиг хэрэг	4,014,039.0	2,877,550.0
210402	Тээвэр, шатахуун	1,021,500.0	2,440,200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,721,440.0	2,101,520.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	940,960.0	616,630.0
2105	Нормативт зардал	15,465,000.0	9,953,800.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,072,140.0	7,308,650.0
210502	Хоол, хүнс	3,392,860.0	2,645,150.0

Архангай аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,328,000.0	4,167,220.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,061,200.0	-
210604	Урсгал засвар	5,266,800.0	4,167,220.0
2107	Томилолт, зочны зардал	27,263,200.0	19,770,000.0
210702	Дотоод албан томилолт	27,263,200.0	19,770,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,680,692.0	10,628,312.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,135,700.0	10,000,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	161,292.0	179,912.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,000.0	41,000.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	640,900.0	-
210807	Газрын төлбөр	80,400.0	80,400.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	29,400.0	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	600,000.0	327,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,182,810.0	1,385,800.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал/Бараа үйлчилгээний бусад зардал	6,783,000.0	1,181,800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,399,810.0	204,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,174,154.3	138,225,764.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,964,035.0	13,695,031.8
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	26,630,035.0	8,095,031.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,334,000.0	5,600,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,210,119.3	124,530,733.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,210,119.3	124,530,733.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III = I -II)	43,911,800.0	7,618,268.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	43,911,800.0	16,605,731.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	43,911,800.0	16,605,731.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	43,911,800.0	16,605,731.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.0	(16,605,731.0)
XII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	(8,987,462.9)
XIII	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,987,462.9	8,987,462.9
XIV	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,987,462.9	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,912,688.0	120,406,296.3	61,517,151.3	317,836,135.6
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	135,912,688.0	120,406,296.3	61,517,151.3	317,836,135.6

Архангай аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,912,688.0	120,406,296.3	61,517,151.3	317,836,135.6
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	186,601,962.2	186,601,962.2
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	135,912,688.0	120,406,296.3	248,119,113.5	504,438,097.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
02	I. ОРЛОГЫН ДҮН	835,451,200.0	943,793,490.0	(108,342,290.0)	113.0
120004101	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000,000.0	182,524,090.0	(112,524,090.0)	260.7
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	765,451,200.0	761,269,400.0	4,181,800.0	99.5
19	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	835,451,200.0	822,135,219.9	13,315,980.1	98.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	827,316,100.0	814,040,188.1	13,275,911.9	98.4
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	827,316,100.0	814,040,188.1	13,275,911.9	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	612,586,800.0	612,586,799.4	0.6	100.0
210101	Үндсэн цалин	330,199,900.0	322,541,829.8	7,658,070.2	97.7
210102	Нэмэгдэл	173,358,700.0	171,302,285.7	2,056,414.3	98.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,479,500.0	70,194,083.9	(9,714,583.9)	116.1
210104	Урамшуулал	48,548,700.0	48,548,600.0	100.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,334,500.0	79,334,500.0	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	55,323,400.0	55,323,400.0	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,002,800.0	6,002,800.0	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,002,900.0	3,002,900.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,999,900.0	2,999,900.0	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,005,500.0	12,005,500.0	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,220,000.0	52,087,125.7	6,132,874.3	89.5
210301	Гэрэл, цахилгаан	4,488,400.0	3,937,928.0	550,472.0	87.7
210302	Түлш, халаалт	51,237,500.0	45,494,881.0	5,742,619.0	88.8
210303	Цэвэр, бохир ус	2,494,100.0	2,654,316.7	(160,216.7)	106.4
2104	Хангамж бараа материалын зардал	10,274,900.0	8,035,900.0	2,239,000.0	78.2
210401	Бичиг хэрэг	2,496,400.0	2,877,550.0	(381,150.0)	115.3
210402	Тээвэр, шатахуун	3,981,000.0	2,440,200.0	1,540,800.0	61.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,658,800.0	2,101,520.0	557,280.0	79.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	161,400.0	-	161,400.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	977,300.0	616,630.0	360,670.0	63.1
2105	Нормативт зардал	14,426,700.0	9,953,800.0	4,472,900.0	69.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,975,800.0	7,308,650.0	2,667,150.0	73.3
210502	Хоол, хүнс	3,455,500.0	2,645,150.0	810,350.0	76.5

Архангай аймгийн Стандарт, хэмжилзүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	995,400.0	-	995,400.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,453,000.0	19,452,951.0	49.0	100.0
210604	Урсгал засвар	19,453,000.0	19,452,951.0	49.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	19,800,000.0	19,770,000.0	30,000.0	99.8
210702	Дотоод албан томилолт	19,800,000.0	19,770,000.0	30,000.0	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,349,400.0	11,948,312.0	401,088.0	96.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,200,000.0	10,000,000.0	200,000.0	98.0
210803	Даатгалын үйлчилгээ	185,900.0	179,912.0	5,988.0	96.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.0	41,000.0	15,000.0	73.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,000.0	-	39,000.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,368,700.0	1,320,000.0	48,700.0	96.4
210807	Газрын төлбөр	80,400.0	80,400.0	-	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	19,900.0	-	19,900.0	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	399,500.0	327,000.0	72,500.0	81.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	870,800.0	870,800.0	-	100.0
21090101	Бараа материал худалдсаны зардал	666,800.0	666,800.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	204,000.0	204,000.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,135,100.0	8,095,031.8	40,068.2	99.5
2132	БУСАД УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,135,100.0	8,095,031.8	40,068.2	99.5
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,135,100.0	8,095,031.8	40,068.2	99.5
991061	III. БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	100.0
9910610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
991062	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.0	19.0	2.0	90.5
9910620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
9910620002	Гүйцэтгэх ажилтан	17.0	15.0	2.0	88.2
9910620003	Үйлчлэх ажилтан	3.0	3.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
02	I. ОРЛОГЫН ДҮН	69,867,900.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,867,900.0
19	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	69,867,900.0
210102	Нэмэгдэл	61,517,265.9
210201	Тэтгэврийн даатгал	5,899,783.0
210202	Тэтгэмжийн даатгал	583,635.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	408,128.0
210204	Ажилгүйдлийн даатгал	291,817.8
210205	Эрүүл мэндийн даатгал	1,167,270.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,090.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Тайлант онд зарцуулсан 1,090.0 мянган төгрөгийн хүнсний материалыг үлдэгдлээр тайлагнасныг аудитын явцад залрууллаа. Энэ нь НББ-ын тухай хуулийн 5.1.4, 13.1, 14.4.1, 15.1,15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Залруулаагүй нийт 1,785.6 мянган төгрөгийн зөрчил² илэрч төлбөрийн акт тогтоолоо.

Аудитаар залруулагдаагүй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 1,785.6 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 9,225.5 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Тус байгууллагын халаалтын зардлыг гэрээ, нэхэмжлэхийн дүн, мөнгөн гүйлгээний журналаар тулган шалгахад “Эх голомтын илч” ХХК-тай байгуулсан дулаан эрчим хүчээр хангах гэрээний дүнгээс 1,785,985 төгрөгийг үндэслэлгүйгээр илүү шилжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 41 дүгээр зүйлийн 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана 15.2.1.байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, төлбөрийн акт тогтоох

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түлш халаалтын зардлаас 1,785.6 мянган төгрөгийг үндэслэлгүйгээр илүү олгосон байна.	1	1,785.6	1	1,785.6		
Нийт дүн	1	1,785.6	1	1,785.6		

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.